58

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 75 33,
Цахим шуудан: info@mojha.gov.mn,
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024 09 04 № 1/635

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

Танаас ирүүлсэн компанийн дансыг битүүмжилж буй үйл ажиллагааны талаарх “Асуулга”-ын хариуг үүгээр хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт .3. хуудастай.

О.АЛТАНГЭРЭЛ

Ирсэн 09-05 2024

59

МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 50 дугаар зүйлд зааснаар аж ахуйн нэгжийн дансыг битүүмжлэх процесс, түүнтэй холбоотой хууль эрх зүйн актуудын талаар:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 44 дүгээр зүйлд иргэний шийдвэр гүйцэтгэлийг баталгаажуулах буюу гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд бүрэн гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тодорхой нэрлэн заасан бөгөөд 44 дүгээр зүйлийн 44.2.13 дахь хэсэгт "төлбөр төлөгчийн банк, эрх бүхий хуулийн этгээд дэх мөнгөн хадгаламж, харилцах данс дахь хөрөнгөөс суутгал хийх, дансны зарлагын гүйлгээг хаах, эрх бүхий хуулийн этгээдэд данс нээх, эзэмших эрхэд хязгаарлалт тогтоох, эсхүл эзэмшиж байгаа дансны орлого, зарлагын гүйлгээнд хяналт тавих" ажиллагааг шийдвэр гүйцэтгэгч хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Мөн хуулийн 50 дугаар зүйлд банк, эрх бүхий этгээд дэх дансны үлдэгдэл мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, шаардлагатай лавлагаа, тодорхойлолт гаргуулах, төлбөрт суутгах ажиллагааг хэрхэн гүйцэтгэх арга, дэс дараалыг тодорхойлж, журамласан байна.

Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч-иргэн, хуулийн этгээдийн банк дахь мөнгөн хөрөнгийг битүүмжлэх, төлбөрт суутгах эрх зүйн үндэслэлийг Банкны тухай хуульд 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулснаар хэрэгжүүлж эхэлсэн. Улмаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017 он/-д илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгсөн.

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн наймдугаар бүлэг буюу 93-98 дугаар зүйлд төлбөр төлөгч-хуулийн этгээдэд холбогдох төлбөрийг хэрхэн барагдуулах талаар зохицуулсан бөгөөд мөн хуулийн 93.1 дэх хэсэгт "...төлбөр төлөгч-хуулийн этгээдийн мөнгөн хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд түүний өмчлөлд хамаарах гүйлгээнээс, эсхүл гүйлгээнд оруулахыг хязгаарласнаас бусад хөрөнгөөс төлбөрийг суутгана." гэж заасан.

Дээрх зохицуулалт нь төлбөр төлөгч-хуулийн этгээдээс төлбөр гаргуулах ажиллагааны дараалыг тогтоосон бөгөөд уг зохицуулалтын агуулга нь тэргүүн ээлжид мөнгөн хөрөнгөөс шүүхийн шийдвэртэй төлбөрийг суутгах ба хүрэлцэхгүй тохиолдолд түүний дараагийн хөрөнгөөс төлбөр гаргуулах ажиллагааг зохион байгуулахаар хуульчилсан байна.

2.Сүүлийн 10 жилийн хугацаанд дансаа битүүмжлүүлсэн аж ахуйн нэгжийн битүүмжлэгдсэн дансны мөнгөн дүнгийн статистик мэдээллийн талаар:

Өнөөдрийн байдлаар шийдвэр гүйцэтгэх ажиллагааны статистик мэдээгээр биелүүлбэл зохих 3.5 их наяд төгрөг гаргуулах 47819 гүйцэтгэх баримт бичгт ажиллагаа явуулж, 817.1 тэрбум төгрөгийн 18791 гүйцэтгэх баримт бичгийг бодитой биелүүлж, дуусгавар болгосон бөгөөд гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 39.3, мөнгөн дүнгийн биелэлт 23.0 хувьтай ажиллаж байна.

60

Сүүлийн 10 жилийн хугацаанд хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн бусдад төлөх нийт 5.4 их наяд төгрөгийн төлбөртэй 19103 аж ахуйн нэгжид холбогдуулан шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдсан, үүнээс 2.2 их наяд төгрөгийн 12440 гүйцэтгэх баримт бичигт төлбөрийг төлүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг дуусгавар болгон ажиллажээ.

Төлбөр төлөгч-иргэн, хуулийн этгээдийн данс дахь мөнгөн хөрөнгийн мэдээллийг авах, дансыг битүүмжлэх, төлбөрт суутгах ажиллагааг 2014 оноос хойш хэрэгжүүлж, нийт 4.6 их наяд төгрөгийн 18110 гүйцэтгэх баримт бичигт төлбөртэй аж ахуйн нэгжийн дансыг битүүмжилж, орлогоос төлбөр барагдуулах ажиллагааг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээний үр дүнд 10578 гүйцэтгэх баримт бичигт 682.5 тэрбум төгрөгийг данснаас суутгасан байна. Үүнээс:

Д/д	Хугацаа		Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад данс битүүмжилсэн гүйцэтгэх баримт бичиг	Дансны хасалтаар мөнгөн хөрөнгө суутгасан гүйцэтгэх баримт бичиг
1	2014	г/х	605	279
		мөн.дүн	273,7 тэрбум	53,6 тэрбум
2	2015	г/х	854	378
		мөн.дүн	46,3 тэрбум	11,3 тэрбум
3	2016	г/х	1123	618
		мөн.дүн	243,3 тэрбум	72,8 тэрбум
4	2017	г/х	1157	666
		мөн.дүн	222,6 тэрбум	74,6 тэрбум
5	2018	г/х	2282	1615
		мөн.дүн	513,9 тэрбум	64,0 тэрбум
6	2019	г/х	2337	1536
		мөн.дүн	398,9 тэрбум	37,9 тэрбум
7	2020	г/х	1920	1225
		мөн.дүн	327,4 тэрбум	55,0 тэрбум
8	2021	г/х	1546	1025
		мөн.дүн	73,7 тэрбум	38,4 тэрбум
9	2022	г/х	2419	1532
		мөн.дүн	976,3 тэрбум	130,5 тэрбум
10	2023	г/х	2230	1172
		мөн.дүн	893,4 тэрбум	119,4 тэрбум
11	2024	г/х	1637	532
		мөн.дүн	683,0 тэрбум	24,5 тэрбум
Нийт дүн			**18110**	**10578**
			4,6 их наяд	**682,5 тэрбум**

3.Уг процесстой холбогдох харилцааг цаашид хэрхэн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжид эрсдэл багатайгаар шийдвэрлэж болох тухай шийдэл, авах арга хэмжээний талаар:

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч буюу зохигчид харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээн оролцдог бол иргэн, захиргааны

шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувьд төлбөр төлөгч нь шүүхийн шийдвэр гарснаас хойш бусдын өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас эрх ашиг хөндөгдсөн төлбөр авагчийн гаргасан хүсэлтээр холбогдох ажиллагааг үүсгэн хуульд заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг онцлогтой.

Шүүхийн шийдвэр уншиж сонгосон даруйд хүчин төгөлдөр болж, тухайн цаг хугацаанаас эхлэн төлбөр төлөгч-иргэн, хуулийн этгээд нь бусдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, төлбөл зохих төлберийг бүрэн барагдуулахаас хамаарч төлбөр авагчийн хөндөгдсөн эрх сэргээгдэх эсэх асуудал шийдвэрлэгдэнэ.

Цөөнгүй тохиолдолд төлбөр авагчийн хувьд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан багагүй хугацаа зарцуулсан ч шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч төлберийн чадваргүй, үйл ажиллагаа зогссон, хөрөнгө, орлогогүй нь тогтоогдох, эсхүл төлбөр төлөхөөс зайлсхийж хөрөнгө, орлогоо нуун дарагдуулж, хохирол, төлберөө барагдуулахгүй байгаагаас шалтгаалан урт хугацаанд эрх нь хөндөгдөх нөхцөл үүсэж байна.

Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсэн даруйд төлбөр төлөгч-хуулийн этгээдийг дуудан ирүүлж, шүүхийн шийдвэрийг танилцуулж, тайлбар, тодорхойлолт гаргуулан төлберийг сайн дураар төлж барагдуулахыг урьдчилан мэдэгддэг бөгөөд шийдвэр гүйцэтгэгчийн тогтоосон хугацаанд төлберийн үүргээ биелүүлсэн тохиолдолд аж ахуйн нэгжийн харилцах дансыг битүүмжлэх, орлогыг суутгах зэргээр албадлагын арга хэмжээ явагдахгүй байх бүрэн боломжтой юм.

Цаашид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг шинэчлэх хүрээнд иргэн, захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг боловсронгуй болгох талаар судалж байна.

---oOo---